



“БИЧИЛ ЭЙ БИ ЭС ЛОЯАЛТИ ТЗК” ХХК-ИЙН 2024 ОНЫ 1-Р ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Тайлан бэлтгэсэн:

"Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК (Хөрөнгө итгэмжлэн удирдагч)
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Соёлын Төв Өргөө /14200/, 10 давхар, 1005 тоот
Утас: +976-70122346

Гарын үсэг:

Х.Маргад-Эрдэнэ /Гүйцэтгэх захирал/

Тайланг баталсан:

Гарын үсэг:

Н.Гантулга /"Бичил Эй Би Эс Лояалти ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн дарга/

АТА11232-8419868
9024010482

Агуулга

1. ХБҮЦ-ны мэдээлэл3
2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл4
3. Төлөөлөн удирдах зөвлөл5

1. ХБҮЦ-НЫ МЭДЭЭЛЭЛ

"Бичил Эй Би Эс Лояалти ТЗК" ХХК нь 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид "СЗХ" гэх)-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (цаашид "ХБҮЦ" гэх) гаргах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн 100 хувь эзэмшлийн охин компани юм.

"Бичил Эй Би Эс Лояалти ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) нь хараат бус 2 гишүүн, хараат 1 гишүүн, нийт 3 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн даргаар Н.Гантулга, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр М.Оюунтуяа болон Д.Баатаржав нар, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК ажиллаж байна.

"Бичил Эй Би Эс Лояалти ТЗК" ХХК нь 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдөр 20.0 тэрбум төгрөгийн дүн бүхий ХБҮЦ-ыг СЗХ-нд бүртгүүлж 2024 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд амжилттай арилжсан бөгөөд 2024 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн.

Хүснэгт 1. ХБҮЦ-ны ерөнхий мэдээлэл

Мэдээлэл	Үзүүлэлт
ХБҮЦ гаргагч	"Бичил Эй Би Эс Лояалти ТЗК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011856540
Регистрийн дугаар	8419868
ХБҮЦ-ыг бүртгэсэн СЗХ-ны тогтоолын огноо	2024/03/20
ХБҮЦ-ыг бүртгэсэн авсан СЗХ-ны тогтоолын дугаар	87
ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ (төг.)	100,000
ХБҮЦ (ширхэг)	200,000
ХБҮЦ-ны үлдэгдэл (сая төг.)	20,000
ХБҮЦ-ны хүүгийн хувь (жилийн)	18.5%
ХБҮЦ-ны хүү төлөх давтамж	Улирал бүр
ХБҮЦ-ны хүү тооцох хоног	365 хоног
Үндсэн төлбөр төлөх давтамж	Хагас жил тутам

"Бичил Эй Би Эс Лояалти ТЗК" ХХК нь ХБҮЦ-ны төлбөрийг Хүснэгт 2-т харуулсан хуваарийн дагуу төлнө.

Хүснэгт 2. ХБҮЦ-ны төлөлтийн талаарх мэдээлэл

№	Огноо*	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр	Үлдэгдэл
1	2024/07/05	-	922,465,753.42	20,000,000,000.00
2	2024/10/07	5,000,000,000.00	952,876,712.33	15,000,000,000.00
3	2025/01/06	-	691,849,315.07	15,000,000,000.00
4	2025/04/07	5,000,000,000.00	691,849,315.07	10,000,000,000.00
5	2025/07/07	-	461,232,876.71	10,000,000,000.00
6	2025/10/06	5,000,000,000.00	461,232,876.71	5,000,000,000.00
7	2026/01/05	-	230,616,438.36	5,000,000,000.00
8	2026/04/06	5,000,000,000.00	230,616,438.36	-
Нийт		20,000,000,000.00	4,642,739,726.03	

2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл

ХБҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш тайлант хугацааны байдлаар хөрөнгийн багцын хэмжээ 18.88 хувиар буурсан бөгөөд энэ нь хуваарийн дагуу 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдөр төлөгдөх ХБҮЦ-ны үндсэн төлбөрийн 25 хувь буюу 5.0 тэрбум төгрөг болон хүүгийн төлбөрийг цуглуулж эхэлсэнтэй холбоотой юм.

Хүснэгт 3. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын ерөнхий шинж чанар

Хөрөнгийн багцын шинж чанар	2024.04.05	2024.06.30	Өөрчлөлт
Багцын үлдэгдэл	20,000,003,954.38	16,224,029,457.96	-18.88%
Зээлийн дундаж үлдэгдэл	16,090,107.77	15,162,644.35	-5.76%
Хамгийн өндөр дүнтэй 1 зээлийн багцад эзлэх хувь	0.29%	0.36%	0.07%
Хамгийн өндөр дүнтэй 10 зээлийн багцад эзлэх хувь	2.69%	3.25%	0.56%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Хүү /жил/	36.89%	36.95%	0.06%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.ЗҮХ	55.64%	51.23%	-4.41%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Насжилт /сар/	8.66	11.15	28.82%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Үлдэгдэл хугацаа /сар/	33.79	31.65	-6.32%
Сарын дундаж төлбөрийн дүн	996,490.80	1,014,121.29	1.77%
Зээлдэгчдийн сарын дундаж орлого	6,789,924.38	7,178,962.62	5.73%
Зээлийн тоо /нийт/	1243	1070	-13.92%
Зээлдэгчийн төрөл	Иргэн	Иргэн	0.00%
Барьцаа хөрөнгийн төрөл	Автомашин	Автомашин	0.00%
Барьцаа хөрөнгийн үнэлгээ	38,735,660,000.00	34,420,890,000.00	-11.14%
Чанаргүй зээлийн хувь	0.00%	0.05%	0.05%
Багц дахь зээлүүдийн эргэн төлөлт Үүнээс: (өсөн нэмэгдсэн дүнгээр)	-	6,059,695,368.87*	-
Зээлийн үндсэн төлбөр	-	4,780,349,197.88	-
Хүүгийн төлбөр	-	1,277,055,630.33	-
Нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр	-	2,290,540.66	-

*Хөрөнгийн багц дахь зээлүүдийн 2024 оны 6 дугаар сарын эргэн төлөлт болох 2.31 тэрбум төгрөгийг гэрээний дагуу 2024 оны 7 дугаар сарын 03-ны дотор тооцоо нийлж, баталгаажуулан хуваарьт өдөр ТЗК-д шилжүүлнэ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь "Бичил Эй Би Эс Лоялти ТЗК" ХХК-ийн сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг ХБҮЦ-ны төлбөрийг төлөх хугацаатай уялдуулан арилжааны банкуудад хадгаламж хэлбэрээр байршуулж ажилласан бөгөөд 2024 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар ТЗК-ийн хадгаламжийн үлдэгдэл 2.61 тэрбум төгрөг, хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 13.46 хувь, харилцах дансны үлдэгдэл 19.43 сая төгрөг байна

Тайлант хугацаанд "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК нь "Бичил Эй Би Эс Лоялти ТЗК" ХХК-ийн хөрөнгийн багцад өөрчлөлт орсон талаарх мэдээллийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, СЗХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тухай журам"-ын 11.3-т заасны дагуу СЗХ-нд мэдэгдэж ажилласан.

Хүснэгт 4. ХБҮЦ-ны хөрөнгөөр багцад орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл

№	Өөрчлөлт орсон мэдээлэл	Зээлийн тоо	Зээлийн дүн
1	Хаагдсан	205	-
2	Хугацаа хэтэрсэн тул буцаан шилжүүлсэн	-	-
3	Багцад нэмж бүртгэсэн	32	1,004,374,701.46
	Нийт	237	1,004,374,701.46

3. Төлөөлөн удирдах зөвлөл

“Бичил Эй Би Эс Лоялти ТЗК” ХХК-ийг “Бичил Глобус Финанс ББСБ” ХХК нь бүрэн эзэмшдэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь ганц хувьцаа эзэмшигч “Бичил Глобус Финанс ББСБ” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч) байна.

2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 23/27а/03 тоот шийдвэрээр ТУЗ-ийн гишүүнээр Н.Гантулга, М.Оюунтуяа болон Д.Баатаржав нарыг тус сонгож 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар ердийн гишүүн Н.Гантулгыг ТУЗ-ийн даргаар томилсон.

Тайлант хугацаанд ТУЗ нь бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 3 удаа хуралдаж холбогдох тогтоолыг баталсан. Үүнд:

Хүснэгт 5. ТУЗ-ийн шийдвэр, хэрэгжилт

№	Огноо	ТУЗ-ийн шийдвэрийн агуулга	Хэрэгжилт
1	2024.01.17	<ol style="list-style-type: none">ХБҮЦ гаргах тухайХБҮЦ гаргахтай холбоотойгоор мэргэжлийн байгууллагуудыг сонгох тухайСонирхлын зөрчилтэй болон хэмжээний хэлцэлОролцогч талуудтай байгуулах гэрээний төсөл, журам батлах тухайДанс нээх эрх олгох тухайДунд хугацааны санхүүгийн төлөвлөгөөг батлах тухай	<ol style="list-style-type: none">Нийтэд нээлттэй арилжаалах 20 тэрбум төгрөгийн ХБҮЦ ерөнхий нөхцөлийг батлав.ХБҮЦ гаргахтай холбоотойгоор мэргэжлийн байгууллагуудыг сонгов.ХБҮЦ гаргахтай холбоотой анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулах сонирхлын зөрчилтэй болон хэмжээний хэлцлийг батлав.Оролцогч талуудтай байгуулах гэрээ болон үйл ажиллагаанд дагаж мөрдөх журмыг тус тус батлав.Арилжааны банкинд харилцах, хадгаламжийн данс нээх болон ҮЦТХТ, ҮЦК-д үнэт цаасны данс нээх эрхийг ТУЗ-ийн даргад олгов.Компанийн 2023-2025 оны “Дунд хугацааны санхүүгийн төлөвлөгөө”-г батлав.
2	2024.03.12	ҮЦТХТ-д данс нээлгэх тухай	Холбогдох дансыг нээлгэв.
3	2024.05.06	Үйл ажиллагааны зардлын төсвийг батлах тухай	Компанийн 2 дугаар улирлын үйл ажиллагааны зардлын төсвийг батлав.